



ДУГААР #5

2011 оны 9 сарын 23

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Өнгөрсөн Бямба гарагт ЭББ-ийн зохион байгуулсан ОУДС-ийн Намрын Баяр амжилттай болж өнгөрлөө. Цаг агаар эхлээд сэрүүвтэр байсан ч удалгүй үүл нүүж, нар гарч дулаахан сайхан байлаа. (Дунд Сургуулийн Эрхлэгчийн бичсэн мэдээллийг уншаарай)



Энэ өдөр Канадын бүжгийн хамтлагийн бүжигчин Adrian LaChance бидэнд бүжгээ сонирхуулж дараа нь Жонон хамтлагийн хөгжимчид тоглолтоо сонирхууллаа. Намрын баярын талаар багш нар, сурагчид, эцэг эхчүүд сэтгэл өндөр байсан. Баярын үеэр худалдаалагдсан зүйлс хүмүүст таалагдаж дуудлага худалдаанд зориулж анги тус бүрээс бэлтгэсэн сагснууд хүмүүсийн анхаарлыг татаж сурагчдын зохион байгуулсан тоглоомуудад манай хамт олон идэвхтэй оролцож цагийг хөгжилтэй өнгөрүүллээ.



Баярын үеэр хамтдаа цугларч бие биентэйгээ уулзаж танилцсандаа бид баяртай байна. Намрын Баярт ирж оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье. ЭББ энэ Намрын Баярыг жил бүр зохион байгуулж сурагчдын боловсролд хөрөнгө оруулах хандивыг цуглуулдаг. Энэ жилийн Намрын Баяраар бид 3000 орчим ам. долларын хандив цуглуулсан.

Одоо бид удахгүй 11 сард Олон Улсын 7 хоногийг зохион байгуулна. (энэ талаарх мэдээллийг та бүхэнд дараа жич хүргэнэ)

Бид удахгүй спортын шинэ талбайтай болох гэж хүлээж байна. Дараах зурагнуудаас та бүхэн манай шинээр хийгдэж байгаа ногоон зүлэгтэй спортын талбай ямар болж өөрчлөгдөхийг хараарай.

Бид 10 сарын 7-ны Баасан гарагт шинэ талбайн нээлтээ хийхээр төлөвлөж байгаа бөгөөд 10-р ангийн сурагчийн зохион байгуулах хөл бөмбөгийн тэмцээнийг 10 сарын 8-ны Бямба гарагт шинэ талбайдаа явуулах болно.

Та бүхэн амралтын өдрүүдээ ая тухтай өнгөрүүлээрэй.




Захирал Robert Stearns

THE MEDIEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

Бид тун удахгүй спортын шинэ талбайн нээлтийг хийхээр хүлээж байна.



ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД

10 сарын 8
10 сарын 9-14

ОУДС-ийн Хөл Бөмбөгийн Тэмцээн 11:00-17:00
Магадлан Итгэмжлэлийн шалгалтын айлчлал

10 сарын 17-25
10 сарын 24, 25

Намрын Амралт
Багш нарын мэргэжил дээшлүүлэх өдөр

ISU Soccer Tournament

When: TBA or October 8th 2011

Time: 11:00am – 5:00pm

Where: ISU Soccer Field

Who: Secondary students, teachers and parents

Entry Fee: \$3,000 per person

Registration: Board near pool table, "ISU Soccer Tournament" on [Facebook](#)

Questions: Ask [Sung Eun](#) in 10th grade



ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өнгөрсөн долоо хоногт Намрын Баяр амжилттай болж өнгөрлөө. Сонирхолтой тоглоомууд тоглуулсан нийт багш нар, сурагчиддаа баярлалаа. Сурагчид цагийг хөгжилтэй өнгөрүүлж шагналын ширээ рүү уралдан гүйцгээж байлаа. Анх удаагаа сагстай дуудлага худалдаа зохион байгуулсан нь амжилттай боллоо. Бараг хүн бүхэн кофе-нд дуртай юм шиг байна. Кофений сагсыг бэлтгэж хамгийн өндөр үнээр худалдсан бэлтгэл ангийн багш сурагчиддаа баярлалаа.

Намрын баярыг зохион байгуулахад идэвхтэй оролцсон багш, эцэг эхчүүддээ болон онцгойлон Ms. Pam Mewbourn, Karen-Bailey Summers, Elizabeth Bailey-Summers, Эрдэнэбилэг, Elena Marchenko нарт баярлалаа. Та бүхний тусламж дэмжлэггүйгээр энэ баяр болохгүй байх байлаа.

Волейболын багийн тамирчид маань тэмцээний өмнөх бэлтгэлээ хийж хэд хэдэн тоглолт зохион байгууллаа. Охидын багийн дасгалжуулагч Kristen Idiens Улаанбаатарын хэд хэдэн сургуулиудтай спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар боллоо.

Ахлах ангийн сурагчдаас бүрдсэн Залуу Аялагчдын Клубын гишүүд энэ амралтын өдрүүдэд нэг хоногоор явган аялал хийх гэж байна. Бид энэ аялалын талаар удахгүй та бүхэнд мэдээлэл хүргэх болно. Танхимаас гадуур сурагчдын дунд зохиох арга хэмжээнүүдийг нэмэгдүүлнэ гэж стратеги төлөвлөгөөнд заасны дагуу Mr. Dave Chilton сурагчдын дунд энэ аялалыг зохион байгуулж байгаад баяртай байна.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Тоглоомын асфалтан талбай дээр ногоон зүлэг дэвсэж байгааг харахад сайхан байна. Хэдэн долоо хоногийн дараа талбай маань сурагчид тоглоход бэлэн болно. Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

СПОРТЫН МЭДЭЭ



Хөвгүүдийн волейболын баг энэ улирлын тоглолтуудаа хийж эхэллээ. 7-12-р ангийн сурагчдаас 12 сурагчийг шигшиж сургуулийн багийг бүрдүүлсэн. Волейболын багийхан тэмцээний бэлтгэлээ хийж байна. Энэ жилийн ACAMIS волейболын тэмцээн 10 сарын 27-29-нд Бээжин хотын BISS олон улсын сургууль дээр зохиогдоно. Манай Бүргэдүүд багийхан сүүлийн хоёр жил тэмцээний аваргаар тодроод байгаа. Францчуудын ярьдгаар хоёр түрүүлчихсэн юм чинь гурав дахиа заавал түрүүлэх учраас бид гуравдахь удаагийн аварга болохоор бэлтгэж байна. Тамирчид маань ч бэлтгэлээ сайн хийж байгаа. Өнгөрсөн Баасан гарагт хөвгүүдийн баг Америкийн Дунд Сургуулийн багтай тэмцээн зохиож 3:0-ийн харьцаатай хожсон. Бүргэдүүдээ амжилт хүсье!

Дасгалжуулагч Philippe Durant

2011 оны Охидын Волейболын баг



Охидын баг тамирчид маань бүх хүчээ дайчлан ACAMIS тэмцээнд амжилттай оролцохоор бэлтгэлээ хийж байна. Өнгөрсөн долоо хоногт охидын баг Америкийн Дунд Сургуулийн багтай тэмцээн зохиож 3:0-ийн харьцаатай хожлоо. Энэ тэмцээний үеэр охидын баг тамирчид маань тоглолтын ур чадвараа дээшлүүлэхэд цаашид юун дээр анхаарч ажиллах ёстойгоо энэ үеэр мэдэж авсан бөгөөд тэмцээнд бэлтгэж цаашид хэд хэдэн тоглолт хийхээр төлөвлөж байна. Тэмцээний улирлын гараагаа амжилттай эхэлсэн охидууддаа баяр хүргэе. Та бүхэн бэлтгэл сургуулиа улам сайн хийж тэмцээндээ амжилттай оролцоорой.

Дасгалжуулагч Kristen Idiens

T-SHIRT DESIGN CONTEST!

Design a t-shirt with the **school mascot** (Golden Eagle), **colors** (black & gold) and **name** (ISU).

Submit your design and have a chance at winning a free t-shirt!

Deadline

Friday, 30th
September 2011

Turn it in to your
Student Council
representative.



**Win a free
t-shirt with your
design on it!**